



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2000 оны хоёрдугаар сарын 5

№5 (142)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

42. Онцгой албан татварын хуульд нэмэлт оруулах тухай	(2000-1-27-ны хууль)	74
43. Гаалийн тарифын тухай хуульд нэмэлт оруулах тухай	(2000-1-27-ны хууль)	74
44. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай	(2000-1-27-ны хууль)	74
45. Онцгой албан татварын хуульд нэмэлт оруулах тухай	(2000-1-28-ны хууль)	74
46. Нэмэгдсэн өртгийн албан татварын хуульд нэмэлт оруулах тухай	(2000-1-28-ны хууль)	75
47. Гаалийн тарифын тухай хуульд нэмэлт оруулах тухай	(2000-1-27-ны хууль)	75
48. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	(2000-1-28-ны хууль)	75
49. Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	(2000-1-28-ны хууль)	76

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

50. Улсын Их Хурлын гишүүний орон тооны ажилтны цалинг тогтоох тухай	Дугаар 13	76
51. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл байгуулах тухай	Дугаар 14	76
52. Тогтоолд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 15	77
53. Мөнгөн төлбөрийн суурь хэмжээг тогтоох тухай	Дугаар 16	77
54. Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээг тогтоох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 17	77

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

55. Чүлтэмийн Шаариймаад Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай	Дугаар 09	77
56. Зарим багш нарт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай	Дугаар 10	78
57. Гүнтэвийн Цагаанхүүд Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай	Дугаар 11	78
58. Сайжрахын Нацагдоржид Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай	Дугаар 12	78
59. Намсрайн Баатарболдод Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээх тухай	Дугаар 13	78
60. Очирхуягийн Эрдэнэцэцэгт Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай	Дугаар 14	79
61. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай	Дугаар 15	79

### Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

62. Тогтоолын заалтад өөрчлөлт оруулах тухай	Дугаар 193	82
63. Төрийн Захиргаа, Удирдлагын хөгжлийн институтийг Удирдлагын академи болгох, түүний дүрмийг батлах тухай	Дугаар 197	83
64 Зардлын норматив, журам батлах тухай	Дугаар 198	86



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

### ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Онцгой албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 6 дахь заалт нэмсүгэй:

дизелийн түлш."

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2000 оны 2 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

"6/газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах зарчмаар Засгийн газартай байгуулсан гэрээний дагуу газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд зориулан импортлолсон автобензин,

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

### ГААЛИЙН ТАРИФЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гаалийн тарифын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай 6, 7, 8 дахь заалт нэмсүгэй:

хуваах зарчмаар Засгийн газартай байгуулсан гэрээний дагуу газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд зориулан буцаан гаргах нөхцөлтэйгээр гаалийн нутаг дэвсгэрт оруулсан техник, тоног төхөөрөмжийг буцаан гаргах;

"6/газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах зарчмаар Засгийн газартай байгуулсан гэрээний дагуу газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд шаардагдах техник, тоног төхөөрөмж, материал, түүхий эд, сэлбэг хэрэгсэл, автобензин, дизелийн түлш, ажиллагсдын хэрэгцээний хүнсний болон хувийн хэрэглээний зүйл;

8/гэрээлэгчийн хуваарьт газрын тосыг гаргах;"

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2000 оны 2 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

7/ газрын тосны салбарт бүтээгдэхүүн

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

### НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт дор дурдсан агуулгатай 12 дахь заалт нэмсүгэй:

түүхий эд, сэлбэг хэрэгсэл, автобензин, дизелийн түлш, ажиллагсдын хэрэгцээний хүнсний болон хувийн хэрэглээний зүйл."

"9.2.12.газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах зарчмаар Засгийн газартай байгуулсан гэрээний дагуу газрын тостой холбогдсон үйл ажиллагаанд зориулан импортлолсон техник, тоног төхөөрөмж, материал,

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2000 оны 2 дугаар сарын 5-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

### ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Онцгой албан татварын хуулийн 7 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 7 дахь заалт нэмсүгэй:

байгууллагад нэг жилээс дээш хугацаагаар томилогдон ажиллаад эх орондоо бүрмөсөн буцаж ирж байгаа иргэний хувийн хэрэглээний суудлын автомашин /1-ээс илүүгүй/."

"7/гадаад орнууд дахь Монгол Улсын дипломат болон консулын төлөөлөгчийн газарт, түүнчлэн Засгийн газар хоорондын олон улсын

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

### НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД НЭМЭЛТГ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт дор дурдсан агуулгатай 13 дахь заалт нэмсүгэй.

хоорондын олон улсын байгууллагад нэг жилээс дээш хугацаагаар томилогдон ажиллаад эх орондоо бүрмөсөн буцаж ирж байгаа иргэний хувийн хэрэглээний суудлын автомашин /1-ээс илүүгүй/."

"13/гадаад орнууд дахь Монгол Улсын дипломат болон консулын төлөөлөгчийн газарт, түүнчлэн Засгийн газар

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Р. ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

### ГААЛИЙН ТАРИФЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТГ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гаалийн тарифын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай 12 дахь заалт нэмсүгэй:

олон улсын байгууллагад нэг жилээс дээш хугацаагаар томилогдон ажиллаад эх орондоо бүрмөсөн буцаж ирж байгаа иргэний хувийн хэрэглээний суудлын автомашин /1-ээс илүүгүй/".

"12/гадаад орнууд дахь Монгол Улсын дипломат болон консулын төлөөлөгчийн газарт, түүнчлэн Засгийн газар хоорондын

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Р. ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

### НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг "1.Даатгуулагч хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн болон түүнтэй адилтгах хүчин зүйлийн үйлчлэлд өртөхийг үйлдвэрлэлийн осол гэнэ. Даатгуулагч хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцдаа богино хугацаанд цацраг идэвхт буюу химийн бодисын нөлөөгөөр хордохыг хурц хордлого гэнэ. Хурц хордлогыг үйлдвэрлэлийн осолтой адилтган үзнэ."; 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг "1.Хөдөлмөрлөх явцад үүссэн үйлдвэрлэлийн сөрөг хүчин зүйлийн

нөлөөллөөс шалтгаалсан өвчнийг мэргэжлээс шалтгаалсан өвчин гэнэ." гэж тус тус өөрчлөн найруулсугай.

2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "осолд" гэснийг "осол, хурц хордлогод" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Р. ГОНЧИГДОРЖ



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

### ИРГЭНИЙ ЦЭРГИЙН ҮҮРГИЙН БОЛОН ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛГ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 2 дахь өгүүлбэрийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

хэлбэрээр орлуулан хаах болзыг Улсын Их Хурал батална. Мөнгөн төлбөрийн хэмжээг Засгийн газар жил бүр тогтооно."

"Уг албыг иргэн мөнгөн төлбөрийн

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Р. ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Улсын Их Хурлын гишүүний орон тооны ажилтны цалинг тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

2.1997 оноос хойш төрийн албан хаагчдад олгосон цалингийн нэмэгдлүүдийн жишгээр Улсын Их Хурлын гишүүдийн одоо ажиллаж байгаа орон тооны ажилтанд ажилласан хугацааг нь тооцож нэмэгдлийг нөхөн олгохыг Улсын Их Хурлын Тамгын газар /Б.Энэбиш-т даалгасугай.

1.Улсын Их Хурлын гишүүний орон тооны ажилтны цалингийн хэмжээг 2000 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 25 хувиар нэмэгдүүлсүгэй.

ДАРГА

Р. ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл байгуулах тухай

Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

М.Чимэддорж -Монголын боловсрол, шинжлэх ухааны УЗ-ийн чөлөөт холбооны дарга;

1.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

4/ажил олгогчийг төлөөлсөн гишүүнээр:

1/Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга:

Д.Жанцан -Монголын ажил олгогч эздийн холбооны дэд ерөнхийлөгч;

-Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга;

Х.Магсаржав -"Мах импекс" ХК-ийн дотоод ажлын албаны дарга;

2/Засгийн газрыг төлөөлсөн гишүүнээр:

Р.Лутаа -"Оёмол бүтээгдэхүүн" үйлдвэрлэгчдийн холбооны ерөнхийлөгч, "Тахь Ко"ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга.

-Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

2.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрмийг хуулийн үзэл санааны дагуу шинэчлэн боловсруулж, Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороогоор батлуулахыг Үндэсний зөвлөл /А.Зангад/-д даалгасугай.

-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын албаны дарга;

3.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүн албан тушаалаас өөрчлөгдөх зэргээр тухайн талаа төлөөлөх боломжгүй болсон нөхцөлд шинээр томилогдох гишүүнийг хуульд заасны дагуу Улсын Их Хуралд оруулж шийдвэрлүүлж байхыг Нийгмийн бодлогын байнгын хороо /Р.Нарангэрэл/-нд даалгасугай.

3/даатгуулагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалсан үйлдвэрчний эвлэлийг төлөөлсөн гишүүнээр:

Д.Нармандах -МУЭ-үүдийн холбооны дэд ерөнхийлөгч;

Д.Нармандах -МУЭ-үүдийн холбооны дэд ерөнхийлөгч;

4.Балжинням -Монголын эрчим хүч, геологи, уул уурхайн ажилчдын УЗ-үүдийн холбооны дарга;

4.Балжинням -Монголын эрчим хүч, геологи, уул уурхайн ажилчдын УЗ-үүдийн холбооны дарга;

ДАРГА

Р. ГОНЧИГДОРЖ



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 1998 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн 81 дүгээр тогтоолын 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалтыг дараахь байдлаар өөрчлөн найруулсугай:

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай  
\*1/Засгийн газраас дайчилгаатай холбогдуулан өмнө баталсан тогтоол шийдвэрийг 2001 онд багтаан Дайчилгааны тухай хууль тогтоомжтой нийцүүлэх;

2/Дайчилгааны тухай хуулиар Засгийн газраас батлахаар заасан дүрэм, журмыг 2001 онд" улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөөг 2002 онд тус тус багтаан гаргах;"

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

Мөнгөн төлбөрийн суурь хэмжээг тогтоох тухай

Цэргийн дүйцүүлэх албыг орлуулан хаах мөнгөн төлбөрийн суурь хэмжээг 1999 онд 638000 /зургаан зуун гучин найман мянга/ төгрөг байхаар тогтоосугай.

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээг тогтоох тухай хуульд өөрчлөлт оруулах

Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээг тогтоох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл буцаах тухай

тухай хуулийн төслийг зүсмэл материалд гаалийн татвар ногдуулах болсноос хойш удаагүй, нэгэнт батлагдсан хуулийн үйлчлэл амьдралд нийцэж байгаа эсэхийг судлахгүйгээр хуульд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэн хууль санаачлагчид буцаасугай.

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРИНГ

2000 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Эрчим хүчний байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж шинэ бүтээл, оновчтой санал гарган үйлдвэрлэлд нэвтрүүлж, үйлдвэрийн үр ашгийг дээшлүүлэх, техник тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах, хэрэглэгчдийг цахилгаанаар хангахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Өмнөговь аймгийн эрчим

Чүлтэмийн Шаариймаад Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай

хүчний үйлдвэрийн засварчин Чүлтэмийн Шаариймаад Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Боловсролын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж сургалтын агуулга, арга зүйг боловсронгуй болгох, өсвөр залуу үеийг сурган хүмүүжүүлэх үйлст оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж дээд сургууль, коллеж, ерөнхий боловсролын сургуулийн дор дурдсан захирал, багш нарт Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

1. Авирмэдийн Баяжих - Нийслэлийн Хан-Уул дүүргийн 52 дугаар дунд сургуулийн бага ангийн сургалт хариуцсан хичээлийн эрхлэгч

Зарим багш нарт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

2. Гүнчингийн Дашдаваа - Хөгжим, бүжгийн коллежийн ёочин хөгжмийн багш

3. Дамжингийн Нямхүү - Дорноговь аймаг дахь Анагаах ухааны коллежийн захирал

4. Шаравын Шагдар - Аялал жуулчлалын удирдлагын дээд сургуулийн дэд захирал

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Эрүүл мэнд, боловсролын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж мэдрэлийн клиникийн эмнэлгүүдийг мэргэжлийн удирдлагаар хангах, материаллаг баазыг бэхжүүлэх, мэдрэлийн өвчний оншлогоо, эмчилгээний шинэ аргуудыг нэвтрүүлэх, боловсон хүчин бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Анагаах

Гүнтэвийн Цагаанхүүд Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай

ухааны их сургуулийн клиникийн профессор Гүнтэвийн Цагаанхүүд Монгол Улсын Хүний гавьяат эмч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн анхан шатны байгууллагад удаан жил үр бүтээлтэй ажиллаж хариуцсан эмнэлгийн материаллаг баазыг бэхжүүлэх, мэс заслын нарийн мэргэжлийн яаралтай тусламжийг хөдөөгийн хөдөлмөрчдөд шуурхай хүргэж, олон зуун хүнийг эмчлэн эдгэрүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь

Сайжрахын Нацагдоржид Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай

үнэлж Баянхонгор аймгийн Жаргалант сумын хүний эмнэлгийн ерөнхий эмч Сайжрахын Нацагдоржид Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Бөхийн самбо барилдааны төрлөөр дэлхий, тив, олон улсын болон Монгол Улсын аврага шалгаруулах тэмцээнд удаа дараа амжилттай оролцож, дэлхийн гурван удаагийн аврага болж, эх орныхоо нэр алдрыг дуурсгасан гавьяаг нь үнэлж Цагдаагийн ерөнхий газрын

Намсрайн Баатарболдод Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээх тухай

"Хүч" спорт хорооны тамирчин, цагдаагийн ахмад Намсрайн Баатарболдод Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Монголын циркийн урлагт удаан жил үр бүтээлтэй ажиллаж агаарын гимнастик, акробат үсрэлт, тулах тэнцвэрийн олон үзүүлбэрийг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэн үзэгчдийн талархал хүлээж, циркийн урлагийн урын санг баяжуулахад оруулж байгаа хувь нэмрийг нь

Очирхуягийн Эрдэнэцэцэгт Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай үнэлж Улсын циркийн жүжигчин Очирхуягийн Эрдэнэцэцэгт Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

Хөдөө аж ахуй, үйлдвэр, худалдаа, үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг, биенийн тамир, спорт, цагдаа, төр, захиргаа болон төрийн бус байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасуугай.

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

11. Гомбогарьдын Лааган - Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын малчин

12. Шагдарсүрэнгийн Лхамсүрэн - Нийслэлийн 17 дугаар сургуулийн бага ангийн сургалт хариуцсан хичээлийн эрхлэгч

13. Самбуугийн Наст - Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын "Соёмбо" цогцолбор сургуулийн бага ангийн багш

14. Сумьяагийн Нэргүй - Нийслэлийн 93 дугаар сургуулийн санаачлагч багш нарын "Авьяс" холбооны тэргүүн

15. Цэдэн-Ишийн Няндаг - Нийслэлийн 93 дугаар сургуулийн зөвлөх багш

16. Пэлжээгийн Онхуудай - Улсын клиникийн төв эмнэлгийн цөмийн онош зүйн тасгийн эрхлэгч

17. Нямжавын Содном - Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ахмадын хорооны дарга

18. Хүрэлийн Сүхбаатар - Техникийн их сургуулийн эрчим хүчний инженерийн сургуулийн багш

19. Хашбатын Хаш-Иш - Нялхсын клиник сувиллын ерөнхий эмч

20. Ожилдойн Хумбаа - Нийслэлийн "АПУ" ХК-ийн шалгагч, уулын спортын тамирчин

21. Батсуурийн Цэрэннадмид - Улсын ардын дуу бүжгийн чуулгын ахмад бүжигчин

ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ УЛААН  
ТУГИЙН ОДОНГООР:

Майдарын Батаев - Цагдаагийн дээд сургуулийн захирал, цагдаагийн хурандаа

### СҮХБААТАРЫН ОДОНГООР:

Бүрэнгийн Бирваа - Эрдэмтэн, судлаач

### ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Батсуурийн Алтангэрэл - Гадаад хэлний "Онол" дээд сургуулийн багш

2. Дамчаагийн Баасанжав - Анагаах ухааны үндэсний хүрээлэнгийн төслийн удридагч

3. Өөдөсийн Базарбат - Үндэсний дуу, бүжгийн "Түмэн эх" чуулгын гоцлол дуучин

4. Хандын Балжгаа - Хараагүй хүмүүсийн хөдөлмөр эрхлэх үйлдвэрийн дэргэдэх "Цацрал" чуулгын дуучин

5. Пүрэвжавын Бямбадорж - Цэцэрлэгийн багшийн коллежийн тэнхмийн эрхлэгч

6. Дашзэвэгийн Галсантогтох - Чөлөөт уран бүтээлч

7. Дарьжавын Гомбожав - Монгол Улсын их сургуулийн утга зохиолын тэнхмийн зөвлөх багш

8. Лувсансодовын Должин - Нийслэлийн 2-р амаржих газрын эмч

9. Баярахын Дүгэр - Нийслэлийн гадаад хэлний "Орхон" дээд сургуулийн багш

10. Сүрэнгийн Жүнш - Архангай аймгийн ахмад уран бүтээлч



## "АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Балданжавын Ариунсан - Улсын нийгмийн халамжийн газрын дарга

2. Бямбын Арьяа - Дундговь аймгийн Сайн цагаан сумын "Баянговь мандал" ХХК-ын аж ахуйн дарга

3. Дорждэрэмийн Баасан - Нийслэлийн жижиг савхин эдлэлийн "Мон-Ланс" ХХК-ийн ерөнхий захирал

4. Доржсүрэнгийн Баасанжав - Булган аймгийн МАХН-ын хорооны улс төрийн ажилтан

5. Шаравын Бадам - Монгол Улсын Их Хурал дахь МАХН-ын бүлгийн зөвлөх

6. Ядамсүрэнгийн Байгалмаа - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 18 дугаар хорооны засаг дарга

7. Хандын Банзар - Нийслэлийн "Намдолдэчинлэн" хийдийн хамба лам

8. Дамдинсүрэнгийн Батдорж - Монгол цэргийн музейн ерөнхий захирал

9. Пагмын Батринчин - Гэгээрлийн яамны стратегийн удирдлага, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн

10. Чимэддоогийн Батсүрэн - Хэнтий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгч

11. Нанзадын Баяр - "Монголын Цахилгаан холбоо" компанийн дэмжүүлэх байгууламжийн ашиглалтын газрын инженер

12. Дондогийн Баясгалан - Нийслэлийн "Ирээдүй" цогцолбор сургуулийн бага ангийн багш

13. Должингийн Болд - Баянхонгор аймгийн холбооны газрын ерөнхий инженер

14. Натаагийн Болд - Нийслэлийн 40 дүгээр сургуулийн захирал

15. Тэгшмэндийн Болдбаатар - Увс аймгийн Цагаанхайрхан сумын Засаг дарга

16. Лхамхүүгийн Бямбаа - Говьсүмбэр аймгийн нефть хангамжийн газрын дарга

17. Жамъянгийн Бямбасүрэн - Техникийн их сургуулийн Өвөрхангай аймаг дахь технологийн сургуулийн сургалтын албаны дарга

18. Түвдэнгийн Ганбат - Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Ахмадын хорооны дарга

19. Дэмчигдоржийн Гарамханд - Үндэсний төв архивын архивч

20. Дандарын Гомбосүрэн - Булган аймгийн Булган сумын өндөр настан, зоотехникч

21. Шагдарын Гүүрэнзаан - Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын "Авто жинчин" ХК-ийн ерөнхий нягтлан бодогч

22. Гончигийн Дагва - Нийслэлийн Багануур дүүргийн дулааны цахилгаан станцын дарга

23. Дамдинсүрэнгийн Дагвадорж - Нийслэлийн орон сууц, нийтийн аж ахуйн 3 дугаар конторын дарга

24. Довдонгийн Дамдинсүрэн - Архангай аймаг дахь Багшийн коллежийн багш

25. Жамбалын Дамдинсүрэн - Дорноговь аймгийн Алтанширээ сумын "Саруул зам" хоршооны малчин

26. Лодойсамбуугийн Дамдинсүрэн - Хөвсгөл аймгийн нийгмийн эрүүл мэндийн төвийн захирал

27. Нансалмаагийн Дашдаваа - Цагдаагийн дээд сургуулийн дэд захирал, цагдаагийн хурандаа

28. Далайн Дашжамц - Техникийн их сургуулийн Барилга, инженерийн сургуулийн барилгын конструкци, технологийн тэнхмийн эрхлэгч

29. Гончигийн Дашхүү - Улсын хүүхэд, залуучуудын театрын жүжигчин

30. Далантайн Дуламжав - Нийслэлийн 13 дугаар дунд сургуулийн бага ангийн багш

31. Бэх-Очирын Дунгаамаа - Нийслэлийн хувцас загварын "Ганга гоёл" ХХК-ийн ерөнхий захирал

32. Лувсан-Очирын Дондог - Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтийн ерөнхийлөгч

33. Шаравын Дэлгэрцэцэг - Улсын ардын дуу бүжгийн чуулгын ахмад бүжигчин

34. Ширнэнгийн Ендондаш - Дугуйн спортын ахмад тамирчин





35. Гэндэнгийн Ишдорж - "МИАТ" компанийн сургалт дадлагын төвийн техникч

36. Лувсандоржийн Маам - Төв аймгийн Цээл сумын Засаг даргын Тамгын газрын ажилтан

37. Гомбын Маамуу - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн хөдөлмөр зохицуулалтын албаны дарга

38. Алтанбаярын Мөнгөнцэцэг - Монгол Улсын Их сургуулийн химийн факультетийн багш

39. Навааны Намхай - Улсын циркийн найруулагч

40. Шагдарын Намхайнямбуу - Нийслэлийн тээвэр, зуулчлалын "Туушин" ХХК-ийн зөвлөх

41. Ерөөлтийн Наранцэцэг - Ахмад уран бүтээлч

42. Маналжавын Нармандах - Монголын хөдөө аж ахуй, хүнсний ажилчдын үйлдвэрчний эвлэлийн холбооны нарийн бичгийн дарга

43. Зундуйн Нямдорж - Монгол хэл бичгийн дээд сургуулийн зөвлөх багш

44. Билэгтийн Палам - Шинжлэх ухааны академийн физик, технологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан

45. Дамдинсүрэнгийн Отгон - Нийслэлийн 2 дугаар амаржих газрын эрчимт эмчилгээ, сэхээний сувилагч

46. Магваны Онон - "Монголын цахилгаан холбоо" компанийн дамжуулах байгууламжийн ашиглалтын газрын ерөнхий инженер

47. Энэбишийн Оюунбат - Сонгодог урлагийн академик театрын гоцлол бүжигчин

48. Цагаанхүүгийн Оюундэлгэр - Увс аймгийн Нийгмийн эрүүл мэндийн төвийн орлогч дарга

49. Балгансүрэнгийн Роломжав - Нийслэлийн 76 дугаар дунд сургуулийн химийн багш

50. Лувсангийн Самбалхүндэв - Хөгжим бүжгийн коллежийн хөгжмийн багш

51. Дэндэвийн Санжмятав - Ширээний теннисийн ахмад дасгалжуулагч

52. Дондогийн Сумъяа - "Монголын цахилгаан холбоо" компанийн дамжуулах байгууламжийн ашиглалтын газрын дарга

53. Замандийн Сумъяа - Архангай аймгийн Тариат сумын малчин

54. Чулуунбатын Сосорбарам - Баянхонгор аймгийн зураач, урчуудын холбооны зураач, барималч

55. Доржхүүгийн Сүгжлхам - Дорноговь аймгийн Сайншанд сумын "Их говийн наран" ХК-ийн нягтлан бодогч

56. Дуламын Сүх - Завхан аймгийн Яруу сумын малчин

57. Банзарын Сүхбаатар - "Нефть импорт концерн" ХК-ийн дэд захирал

58. Дарьсүрэнгийн Сүхбаатар - Нүүдэлчдийн соёл иргэншлийн олон улсын төвийн тэргүүн

59. Өлзийн Сүхээ - Нийслэлийн "Морины шандас" ХХК-ийн жолооч

60. Зодовын Торгоош - Төв аймгийн Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын албаны дарга

61. Пунцагбаатарын Төртогтох - Завхан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн дарга

62. Лувсан-Ойдовын Тулгаа - Гэмтэл согогийн клиникийн эмнэлгийн түлэнхийн төвийн тасгийн эрхлэгч эмч

63. Самдангийн Урмаа - Нийслэлийн 89 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч

64. Дагвийбазарын Халтар - Сэтгэцийн эмгэгийн клиникийн эмнэлгийн бага эмч

65. Мэндийн Хандсүрэн - Нийслэлийн 110 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

66. Самбуугийн Хандсүрэн - Нийслэлийн "Ирээдүй" цогцолбор сургуулийн орос хэлний багш

67. Балдан-Осорын Хоролсүрэн - Нийслэлийн "Уян сервис" ХХК-ийн инженер технологич

68. Пиадарын Цолмон - Нийслэлийн 65 дугаар сургуулийн багш

69. Балбарын Цэдэв - Эрдэм шинжилгээний байгууллагын ахмад ажилтан

70. Дүгэрмаагийн Цэрмаа - Дархан-Уул аймгийн Ургамал, газар тариалан, сургалт эрдэм шинжилгээний хүрээлэнгийн дэд захирал

71. Дансрангийн Цэрэн - Анагаах ухааны их сургуулийн оюутны байрны захирал

72. Өлзийхутагийн Цэрэн - Техникийн их сургуулийн математикийн тэнхимийн багш



73. Норжингийн Чулуун - Нийслэлийн 82 дугаар сургуулийн газар зүйн багш

74. Доржийн Чулуунсүрэн - Төв аймгийн Зуунмод сумын 4 дүгээр сургуулийн хичээлийн эрхлэгч

75. Цэрэнгийн Чулуунцэцэг - Үндэсний дуу, бүжгийн "Түмэн эх" чуулгын дуучин

76. Лувсанжавын Чойсүрэн - Нийслэлийн "Эрдмийн ундраа" цогцолбор сургуулийн хичээлийн эрхлэгч

77. Мангалын Шараа - Техникийн их сургуулийн тэнхимийн эрхлэгч

78. Пүрэвийн Энхбаяр - Нийслэлийн 60 дугаар сургуулийн зураг хөдөлмөрийн багш

79. Лувсандоржийн Эрдэнэбаяр - Сэтгэцийн эмгэг, наркологийн төвийн захирал

80. Жамъяангийн Эрдэнэжүгдэр - "Монголын цахилгаан холбоо" компанийн дамжуулах байгууламжийн ашиглалтын газрын мэргэжилтэн

### ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:

Даваагийн Лхагвасүрэн - Цагдаагийн дээд сургуулийн инженер, цагдаагийн дэд хурандаа

### ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Осорын Батсүх - Цагдаагийн дээд сургуулийн жолооны багш

2. Доржжанцангийн Баярмаа - Нийслэлийн "Ирээдүй" цогцолбор сургуулийн зохион бүтээх хөдөлмөрийн багш

3. Билэгтийн Бумаа - Нийслэлийн Багануур дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн сувилагч

4. Дарамын Ганбаатар - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн дэд захирал

5. Чулуунбаатарын Ганбат - Цагдаагийн дээд сургуулийн багш

6. Нүдэнхүүгийн Гипэлмаа - Дорноговь аймгийн Алтанширээ сумын Засаг дарга

7. Гомбожавын Занаа - Хөгжим бүжгийн коллежийн төгөлдөр хуурын багш

8. Санжийн Зоригт - Нийслэлийн 148 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

9. Хувцагааны Ичинноров - Нийслэлийн 119 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч

10. Адъяагийн Нарангэрэл - Нийслэлийн 1 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч

11. Дашнямын Насанжаргал - Худалдаа, Үйлдвэрийн дээд сургуулийн багш

12. Сүндэвийн Оюунчимэг - "Нефть импорт концерн"ХК-ийн бодлого, зохицуулалтын газрын инженер

13. Чилаагийн Тунгалаг - Нийслэлийн 104 дүгээр цэцэрлэгийн багш

14. Дэмбэрэлийн Үдэлгарав - Нийслэлийн "Ирээдүй" цогцолбор сургуулийн химийн багш

15. Товуугийн Пагамдулам - Нийслэлийн "Өөдрөг эхлэл" хоршооны дарга

16. Жамсрангийн Цогзолмаа - Нийслэлийн 110 дугаар цэцэрлэгийн багш

17. Долгорын Цоодол - Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 1 дүгээр дунд сургуулийн бага ангийн багш

18. Гомбын Цэдэв - Нийслэлийн 2 дугаар амаржих газрын ажилчин

19. Цоодолын Цэндсүрэн - Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 1 дүгээр сургуулийн түүх газар зүйн багш

20. Гонгорын Цэрэндэжид - Булган аймгийн Гурван булаг сумын малчин

21. Санжаажамцын Чимгээ - Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

22. Цогтгэрэлийн Эрдэнэцэцэг - "Монголын цахилгаан холбоо" компанийн дамжуулах байгууламжийн ашиглалтын газрын радио релейний шугамын төв станцын дарга

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр

Дугаар 193

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Өрхийн эмнэлэг байгуулан ажиллуулах тухай Засгийн газрын 1999 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 149 дүгээр тогтоолын 3 дугаар заалтын "...мөрдүүлж"

Тогтоолын заалтад өөрчлөлт оруулах тухай гэснийг "...өрхийн эмнэлгийг гэрээний үндсэн дээр санхүүжүүлж" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД  
ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД

Р. АМАРЖАРГАЛ

С. СОНИН



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр

Дугаар 197

Улаанбаатар хот

Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институтийг Удирдлагын академи болгох, түүний дүрмийг батлах тухай

Төрийн албаны боловсон хүчин бэлтгэх тогтолцоог цаашид бэхжүүлж, сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажлын уялдааг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

мэргэжлийн боловсон хүчнээр хангах арга хэмжээ авахыг Удирдлагын академийн захиралд үүрэг болгосугай.

1.Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институтийг Удирдлагын академи болгож, түүний дүрмийг хавсралтын ёсоор баталсугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институтын орон тоо, бүтцийг тогтоох, дүрэм, төсвөөс олгох санхүүжилтийн хэмжээ, сарын цалингийн санг батлах тухай" Засгийн газрын 1994 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 52 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

2.Сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажлын төлөвлөгөө, зохион байгуулалт, хичээлийн хөтөлбөрийн агуулгыг академийн сургалтын шаардлага, түвшинд нийцүүлэн сайжруулж, төрийн албыг өндөр

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД  
ГЭГЭЭРЛИЙН САЙД  
Р.АМАРЖАРГАЛ  
А.БАТТӨР

*Засгийн газрын 1999 оны 197 дугаар тогтоолын хавсралт*

### УДИРДАГЫН АКАДЕМИЙН ДҮРЭМ

#### Нэг.Нийтлэг үндэслэл

өөрийн дотоод дүрэм, журмыг баримтална.

1.Удирдлагын академи нь Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн статус бүхий төрийн албаны мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, төрийн бодлогыг хэрэгжүүлэх сургалт, судалгаа, шинжилгээний байгууллага бөгөөд үүсгэн байгуулагч нь Засгийн газар мөн.

5.Удирдлагын академи нь тогтоосон журмын дагуу үйлдсэн албан бичгийн хэвлэмэл хуудас, тамга, тэмдэг хэрэглэх бөгөөд өөрийн билгэдэл (эмблем, далбаа, энгэрийн тэмдэг)-тэй байна.

#### Хоёр.Удирдлагын академийн үүрэг, эрх

2.Удирдлагын академийн үйл ажиллагааны зорилго нь төрийн албаны болон удирдахуйн ухааны шинэ мэдлэг, ур чадварыг түгээх, төрийн албыг бэхжүүлэх шаардлагад нийцүүлэн мэргэжлийн өндөр чадвар бүхий боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, төрийн удирдлага, үндэсний менежментийн гол зангилаа асуудлаар шинжилгээ судалгаааны ажил гүйцэтгэж, үнэлэлт дүгнэлт гаргах замаар Монгол оронд удирдлагын тогтолцоог хөгжүүлэх, түүний онол, арга зүйн үндсийг бүрдүүлэх явдал мөн.

6.Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг олон улсын жишиг, өөрийн орны төр, бизнес, боловсролын удирдлагыг боловсронгуй болгох шаардлагын дагуу боловсруулж, мөрддөг байх.

7.Удирдлагын академи дараахь хэлбэрүүдээр төрийн захиалгат болон төлбөртэй сургалт явуулна:

а/төрийн захиргаа, бизнесийн болон боловсролын удирдлагаар мэргэшүүлэх дипломын дараахь (мэргэшсэн менежер бэлтгэх) сургалт;

3.Удирдлагын академийг өөрчлөх, үйл ажиллагааг нь зогсоох, татан буулгах асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

б/төрийн албаны дээд зэрэг дэвийн ажилтнуудад зориулсан тусгай сургалт;

4.Удирдлагын академи нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомж, энэхүү дүрэм болон тэдгээрт нийцүүлэн боловсруулсан

в/төрийн захиргаа, бизнесийн болон боловсролын удирдлагын магистрын сургалт;



г/мэргэшил дээшлүүлэх, дахин мэргэшүүлэх богино хугацааны зорилтот сургалт;

д/удирдахуйн ухаанаар доктор (D.Ph)-ын зэрэг олгох сургалт.

8. Удирдлагын академи нь өдөр, эчнээ, орой ("Пүрэв гариг"), экстернат, ажлын байрны сургалт зэрэг албан сургалтаас гадна зайн сургалт явуулна.

9. Удирдлагын академи дараахь хэлбэрүүдээр судалгаа, шинжилгээний ажил эрхлэж, өөрийн орлогоос санхүүжүүлнэ:

а/Монгол орны нөхцөлд тохирсон менежментийн үндэсний загвар боловсруулах судалгаа шинжилгээ эрхлэх;

б/төрийн бодлогын үндэс, төрийн албадын үйл ажиллагааг судлах, улс орны хөгжлийн зангилаа асуудлууд, орчин нөхцөлийн үзэл баримтлалыг боловсруулахад оролцох, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн байдлыг судлах, прогноз хийх;

в/төрийн захиргаа, бизнесийн болон бусад байгууллагын захиалгаар судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх, төсөл боловсруулах, зөвлөлгөө өгөх;

г/эрдэм шинжилгээний хурал, семинар зохион байгуулах;

д/төгсөгчдийн дипломын ажил болон ангийн төслийг байгууллагын захиалгаар бичүүлэх, үр дүнг нь нэвтрүүлэхэд туслалцаа үзүүлэх;

е/Академийн сургалт, эрдэм шинжилгээний ажлын чиглэлд нийцсэн сурах бичиг, гарын авлага, ном зохиол туурвих зэвлүүлэх;

ж/судалгаа, эрдэм шинжилгээний болон сурталчилгааны бүтээл туурвих, нийтийн хүртээл болгох;

з/өөрийн орны болон гадаад орны адил төстэй сургалт, эрдэм шинжилгээний байгууллага, судалгааны төвүүдтэй хамтрах буюу тэдний захиалгаар судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх.

## Гурав. Академийн бүтэц, зохион байгуулалт

10. Удирдлагын академи нь зохион байгуулалтын бүтэц, захиргааны орон тоогоо Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай зөвшилцсөний үндсэн дээр тогтооно.

11. Удирдлагын академийн захирлыг Засгийн газар томилно. Захирал нь академийн үйл ажиллагааг Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын бодлогын дагуу удирдан зохион байгуулах үүргийг Засгийн газрын өмнө хүлээнэ.

12. Академийн дэд захирлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай зөвшилцсөний үндсэн дээр академийн захирал томилно.

13. Академи нь захиргааны зөвлөл, эрдмийн зөвлөл, доктор (D.Ph)-ын зэрэг хамгаалуулах зөвлөл, сургалт арга зүйн зөвлөлтэй байна.

Академийн захирал нь эдгээр зөвлөлийг удирдаж, зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг баталж мөрдүүлнэ.

## Дөрөв. Удирдлагын академи ба төрийн дээд байгууллагуудын харилцаа

14. Удирдлагын академи нь төрийн захиалгаар төрийн албан хаагчдыг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн захиргааны албаны зөвлөлөөр батлуулж мөрдөнө.

15. Удирдлагын академи нь судалгаа, шинжилгээний ажил, докторантурын ажлын сэдвийг Улсын Их Хурал, Засгийн газар, Ерөнхийлөгчийн Тамгын газрын захиалгыг үндэслэн зохих журмын дагуу зарлаж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

16. Төрийн дээд байгууллагуудын захиалгат судалгаа, шинжилгээний ажлыг гүйцэтгэхдээ холбогдох төрийн байгууллагуудаас мэдээллийг зохих журмын дагуу авах буюу ажиглалт судалгаа явуулна.

17. Удирдлагын академи нь үйл ажиллагааныхаа үр дүнг Засгийн газарт тогтоосон журмын дагуу тайлагнана.

## Тав. Суралцагчдыг элсүүлэх, суралцуулах, шилжилт хөдөлгөөнийг зохицуулах

18. Сонсогч, оюутан, магистрант, докторант (цаашид суралцагч гэх) элсүүлэх асуудлыг Засгийн газар, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын хүрээнд академийн элсэлтийн дүрмээр зохицуулна.



19. Суралцагчийг академиас хасах, улируулах, шилжүүлэх, чөлөө олгох асуудлыг тэнхим, сургалтын албаны саналыг үндэслэн тогтоосон журмын дагуу захирлын тушаалаар шийдвэрлэж байна.

20. Сургалтын төлөвлөгөөг бүрэн биелүүлсэн суралцагч нарт диплом (сертификат, үнэмлэх) олгоно.

## Зургаа. Гадаад харилцаа

21. Удирдлагын академи нь Монгол Улсын хууль тогтоомж, төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас тогтоосон дүрэм, журамд нийцүүлэн дараахь чиглэлээр гадаад харилцааны үйл ажиллагаа явуулна:

а/хамтарсан судалгаа, шинжилгээ хийж;

б/багш, суралцагчдыг солилцох;

в/Академийг хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэх ;

г/хамтарсан сургалт, судалгааны төв, лаборатори байгуулах;

д/мэдээлэл солилцох;

е/багш бэлтгэх;

ж/эрдэм шинжилгээ, онол арга зүйн семинар, бага хурал зохион байгуулах;

з/өндөр мэргэжлийн багш, эрдэмтдийг гэрээгээр ажиллуулах.

## Долоо. Санхүү, аж ахуйн үйл ажиллагаа

22. Удирдлагын академи нь төрийн өмчийн, ашгийн бус байгууллага байна.

23. Тус академи нь сургалт, эрдэм шинжилгээний баазыг бэхжүүлэх санхүүгийн эх үүсвэрээ нэмэгдүүлэх, хамт олныхоо нийгмийн баталгааг дээшлүүлэх зорилгоор хууль, тогтоомжид нийцүүлэн төлбөртэй сургалт, судалгаа явуулах, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх зэргээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллана.

24. Хуулиар хориглоогүй бол үйл ажиллагааны үр дүнд олсон орлогоо академийн захиргаа дүрмийнхээ зорилгын дагуу эзэмшиж, захиран зарцуулна.

Удирдлагын академийн санхүүжилтийн эх үүсвэр нь:

а/төвлөрсөн төсвийн санхүүжилт;

б/суралцагчдын төлбөр;

в/өөрийн аж ахуйн үйл ажиллагааны орлого;

г/гадаад, дотоодын дэмжигч, ивээн тэтгэгч байгууллага, хувь хүмүүсийн хандив, зээл, тусламж;

д/бусад эх үүсвэр зэрэг байна.

25. Засгийн газрын захиалгаар суралцагчдын сургалтын төлбөрийг зардлын суурь нормативыг үндэслэн жил бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай зөвшилцөн тогтооно.

## Найм. Удирдлагын шийдвэр, баримт бичиг

26. Удирдлагын академийн захирал тушаал гаргана. Эрдмийн зөвлөл, захиргааны зөвлөлөөс хэлэлцсэн асуудлаараа хурлын шийдвэр, тэмдэглэл гаргана.

27. Удирдлагын академи өөрийн эрдэм шинжилгээний бичиг, хэвлэлтэй байна.

28. Удирдлагын академийн хэмжээнд сурлагын дэвтэр, диплом, сертификат, үнэмлэх, энгэрийн тэмдгийг нэгдсэн загвараар хэвлүүлж хэрэглэнэ.

## Ес. Удирдлагын академийн дүрэм, журам зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

29. Удирдлагын академийн дүрэм, журам зөрчигчдөд холбогдох хууль тогтоомж болон академийн дотоод журамд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр

Дугаар 198

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Зардлын норматив, журам батлах тухай  
Хэрэг эрхлэх газрын дарга Н.Батбаяр нарт даалгасугай.

1.Төр, засгийн шугамаар гадаад, дотоодын зочин төлөөлөгчдөд хүндэтгэлийн зоог барих, хүлээн авалт хийх зардлын нормативыг 1 дүгээр хавсралтын, бэлэг дурсгалын зүйл гардуулах, хүлээн авах, тайлагнах, зарцуулах журмыг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталж, мөрдүүлсүгэй.

3.Эрхэлсэн асуудлын хүрээний байгууллага, орон нутгийн захиргааны байгууллагын удирдлагаас ёслолын арга хэмжээнд зарцуулах зардлын нормативыг Сангийн яамтай зөвшилцөн тогтоож мөрдүүлж ажиллахыг сайд, аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2.Зардлын норматив, журмын биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг зохион байгуулан шаардлагатай тохиолдолд зах зээлийн тухайн үеийн үнэ ханштай уялдуулан нормативт өөрчлөлт оруулах саналаа Засгийн газарт танилцуулж байхыг Сангийн сайд Я.Очирсүх, Засгийн газрын

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД Р.АМАРЖАРГАЛ  
ГАДААД ХАРИЛЦААНЫ  
САЙД Н.ТУЯА  
САНГИЙН САЙД Я.ОЧИРСҮХ

*Засгийн газрын 1999 оны 198 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт*

### ХҮНДЭТГЭЛИЙН ЗООГ БАРИХ, ХҮЛЭЭН АВАЛТ ХИЙХ ЗАРДЛЫН НОРМАТИВ

1.Хүндэтгэлийн зоог барих, хүлээн авалт хийх зардал дор дурдсан хэмжээтэй байна:

а/Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд хүндэтгэлийн зоог барих, хүлээн авалт хийхэд уг ёслолын арга хэмжээнд зориулан хийсэн төсөвт багтаана;

б/Монгол Улсын Гадаад харилцааны сайд болон Засгийн газрын гишүүдээс тэдэнтэй адилтгах зиндааны зочин, төлөөлөгчдөд албан ёсны зоог барихад нэг хүнд ногдох зардал нь 10 хүртэл хүн оролцох зоогт 20000 төгрөг, 50 хүртэл хүн оролцох зоогт 15000 төгрөг, 50-иас дээш хүн оролцох зоогт 10000 төгрөгөөс тус тус илүүгүй байна. Хүлээн авалт хийх зардлыг

2.Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын удирдлага, аймаг, нийслэлийн Засаг дарга, яамдын Төрийн нарийн бичгийн дарга, тэдгээртэй адилтгах албан тушаалтнаас гадаад, дотоодын зочин, төлөөлөгчдөд хийх хүлээн авалтын нэг хүнд ногдох зардал нь 10 хүртэл хүн оролцоход 12000 төгрөг, 50 хүртэл хүн оролцоход 10000 төгрөг, 50-иас дээш хүн оролцоход 8000 төгрөгөөс тус тус илүүгүй байна.

3.Энэхүү хавсралтын 2 дугаар зүйлд заасан хүлээн авалтын арга хэмжээнд архи хэрэглэхийг хориглоно.

*Засгийн газрын 1999 оны 198 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт*

### БЭЛЭГ ДУРСГАЛЫН ЗҮЙЛ ГАРДУУЛАХ, ХҮЛЭЭН АВАХ, ТАЙЛАГНАХ, ЗАРЦУУЛАХ ЖУРАМ

Нэг.Ерөнхий зүйл

1.Монгол Улсын төр, засгийн удирдагчид, Засгийн газрын гишүүд болон Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын удирдлага, аймаг, нийслэлийн

Засаг дарга, тэдгээртэй адилтгах албан тушаалтнаас гадаад, дотоодын зочин, төлөөлөгчдөд бэлэг, дурсгалын зүйл гардуулах, илгээх, хүлээн авах, тэдгээрийг зарцуулах, тайлагнах үйл ажиллагаанд энэхүү журмыг мөрдлөг болгоно.



## Хоёр.Бэлэг, дурсгалын зүйл гардуулах

2.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдаас Монгол Улсад албан ёсны айлчлал хийж буй тэдгээртэй адилтгах зиндааны гадаадын зочин, төлөөлөгчдөд өгөх бэлэг, дурсгалын зүйлийг баталсан төсвийн дагуу Төрийн ёслолын албаны бэлэг дурсгалын сангаас бүртгэл, тайланд тусган гаргаж зочны байранд хүргэж өгнө.

3.Дээрх албан тушаалтан албан ёсны айлчлалаас бусад үед гадаад, дотоодын зочин, төлөөлөгчдөд гарын бэлэг, дурсгалын зүйл гардуулах, илгээхэд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 100,0 мянган төгрөг, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдаас 80,0 мянган төгрөгөөс тус тус илүүгүй үнэтэй зүйл нэг хүнд ногдохоор тооцож Төрийн ёслолын алба бэлэг дурсгалын сангаас бүртгэл, тайланд тусган гаргаж өгнө.

4.Монгол Улсын Гадаад харилцааны сайдаас гадаадын зочин, төлөөлөгчдөд нэг хүнд 65,0 мянган төгрөг, Монгол Улсын сайд болон аймаг, нийслэлийн Засаг дарга, тэдгээртэй адилтгах албан тушаалтнаас тухайн салбар, чиглэлийн шугамаар албан ёсны айлчлал хийж буй ижил зиндааны гадаадын зочин, төлөөлөгчдөд нэг хүнд 50,0 мянган төгрөг, албан айлчлалын бус үеийн гадаад, дотоодын зочин төлөөлөгчдөд нэг хүнд 40,0 мянган төгрөгөөс тус тус илүүгүй үнэтэй зүйл байхаар тооцож уг яам, байгууллагын байрны захиргаа буюу санхүү, аж ахуй хариуцсан алба бүртгэл тайланд тусган гаргаж өгөх ажлыг зохион байгуулна.

5.Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын удирдлагаас гадаад, дотоодын зочин, төлөөлөгчдөд гардуулах бэлэг, дурсгалын зүйлийг нэг хүнд 40,0 мянган төгрөгөөс илүүгүй үнэтэй байхаар тооцож Төрийн ёслолын алба бэлэг дурсгалын сангаас бүртгэн гаргаж олгоно.

6.Зочин, төлөөлөгчдөд өгөх бэлэг, дурсгалын зүйлс нь соёлын чанартай зүйл байх бөгөөд Монгол Улсын хууль тогтоомжоор хориглосон түүх, дурсгалын үнэт эдлэл, байгалийн үнэт эрдэнэс баялгийн болон бусад зүйл байж үл болно.

7.Монгол үндэсний дээл, малгайг Монгол Улсад анх удаа айлчилж буй гадаад улсын төр, засгийн тэргүүн, тэдний гэргий (нөхөр)-д айлчлалын үеийн төсөвт тусган бэлэглэж болно.

8.Зочин, төлөөлөгчдийн очсон байгууллага бүр бэлэг өгөх шаардлагагүй, харин өөрийн танилцуулга, зурагт хуудас, энгэрийн тэмдэг дурсгаж болно.

Бэлгийн зүйлийг тэдгээрийг урьсан байгууллага хариуцна.

9.Дээр дурдсан албан тушаалтнууд гадаад улсад айлчлах, дотоодод томилолтоор ажиллахад шаардагдах бэлэг, дурсгалын зүйлийн хэмжээг энэ бүлэгт заасны нэгэн адил мөрдөнө.

## Гурав. Бэлэг, дурсгалын зүйл хүлээн авах, тайлагнах, зарцуулах

10.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд болон Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын удирдлага гадаад, дотоодын зочин, төлөөлөгч, байгууллага, иргэдээс албан үүрэгтэй нь холбогдуулан өгсөн бэлэг, дурсгалын зүйлсийг Төрийн ёслолын албаар дамжуулан авна. Төрийн ёслолын алба бэлэг, дурсгалын зүйлийг үнэлүүлэн бүртгэлд тусгаж уг зүйл тухайн албан тушаалтны нэг сарын цалингаас илүүгүй үнэтэй бол эзэнд нь шууд дамжуулна. Хэрэв тухайн албан тушаалтан бэлэг, дурсгалын зүйлийг үнэ харгалзахгүйгээр бэлгийн санд шилжүүлэхийг хүсвэл уг зүйлийг зохих журмын дагуу үнэлүүлэн бүртгэж авна.

11.Тухайн албан тушаалтны нэг сарын цалингаас илүү үнэтэй бол Төрийн ёслолын алба дор дурдсан зарчмыг баримтлан шийдвэрлэнэ:

а/бэлгийн зүйлийг үнээр нь үнэлэн бэлгийн санд орлого болгох;



б/тухайн албан тушаалтан бэлэг, дурсгалын зүйлээ хувьдаа авах хүсэлт тавьсан тохиолдолд түүний нэг сарын цалингийн хэмжээнээс илүү гарах зөрүүг өөрөөс нь гаргуулан Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын санхүүд шилжүүлж, уг бэлэг, дурсгалын зүйлийг өөрт нь олгох;

в/зочин, төлөөлөгч, байгууллага, иргэдээс өгсөн бэлэг, дурсгалын зүйл нь түүх, соёл, урлагийн дурсгалт зүйл, эрдэнэсийн сан хөмрөгт орох эдлэл буюу гадаад харилцааны түүхэнд холбогдох ховор эд материалд хамаарах зүйл байвал үнэ харгалзахгүйгээр бэлгийн санд тодорхой бүртгэн авч, шаардлагатай эд зүйлсийг зохих журмын дагуу үндэсний музей болон холбогдох бусад байгууллагад албан баримтаар шилжүүлэх.

12. Дээрх албан тушаалтнуудаас бэлгийн санд бэлэг, дурсгалын зүйлийг хүлээж авсан болон хүлээлгэн өгсөн тухай актыг хоёр хувь үйлдэнэ. Уг актын нэг хувь тухайн албан тушаалтанд, үлдэх хувийг Төрийн ёслолын албаны бэлгийн сан хариуцсан ажилтан хадгалан Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газарт улирал бүр тайлан гаргаж өгнө. Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газар нь дээрх тайланг хагас жил тутам Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт мэдээлж байна.

13. Бэлгийн санд орлого болгосон эд зүйлийг Төрийн ёслолын албанаас Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай зөвшилцөн зориулалтын дагуу ашиглан зарцуулна.

14. Монгол Улсын сайд болон аймаг, нийслэлийн Засаг дарга, тэдгээртэй адилтгах албан тушаалтан зочин, төлөөлөгч, байгууллага, иргэдээс албан үйл ажиллагаатай нь холбогдуулан өгсөн бэлэг, дурсгалын зүйлийг хүлээн авах, тайлагнах, зарцуулах ажиллагааг энэ бүлэгт заасан журмын дагуу холбогдох алба, албан тушаалтнуудаар нэгэн адил гүйцэтгүүлнэ.

## Дөрөв. Бусад зүйл

15. Энэ журамд зааснаас бусад албан тушаалтан, ажилтан нараас албан ажлын шугамаар гадаад, дотоодын зочин, төлөөлөгч, байгууллага, иргэдэд бэлэг, дурсгалын зүйл гардуулах шаардлагатай бол тухайн байгууллагын удирдлагаас тусад нь төсөв батлуулан хэрэгжүүлж болно.

16. Дээрх албан тушаалтан, ажилтан нарт албан ажлынх нь чиг үүрэгтэй холбогдуулан зочин, төлөөлөгч, байгууллага, иргэдээс өгсөн бэлэг, дурсгалын зүйлийг мөн энэ журамд заасныг мөрдлөг болгон шийдвэрлэнэ.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
Ханг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12  
Төрийн ордон

☐ 329612  
Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх үйлдвэрт хэвлэв.

☐ 329487